

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА

В.П. РЭВБААСАН - ДХИС-ИЙН УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН
ХИЛИЙН АЛБАНЫ УДИРДЛАГА, СТРАТЕГИЙН ПРОФЕССОРЫН
БАГИЙН ДЭД ПРОФЕССОР, ХУРАНДАА, ДОКТОРАНТ

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ЦЭРГИЙН АЛБАНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗАРИМ АСУУДЛУУД

/SECURITY OF MILITARY SERVICE AND ITS THEORETICAL CONCEPT/

Төвлөрөл: Хил хамгаалах байгууллагын Цэргийн албаны аюулгүй байдал

Key words: Security of military service /SMS/

ОРШИЛ

Судалгаанаас “Цэргийн аюулгүй байдал нь бус нутаг, улс орны хэмжээнд яригдах өргөн утга агуулгатай төрийн улсыг гадны улсын цэргийн аюулаас хамгаалах зорилго бүхий улс төр-цэргийн бодлогын асуудал юм. Харин цэргийн албаны аюулгүй байдал нь дотоод үйл ажиллагааны агуулгатай ЦАХ-ийг дор тутмын ажил өргөө гүйцэтгэх үеийн аюулгүй байдлыг хангах зорилго бүхий бүх төрлийн алба, үйл ажиллагааны цогц юм.” хэмээн судлаачийн хувьд дүгнэж байна.

Цэргийн албаны аюулгүй байдлын онолын тухай ярихын тулд ямар ч салбарт аюулгүй байдлыг хангах нь юуны өмнө практик ажил хэрэг байсан, байх ч болно. Гэхдээ нийгэм төр төрийнхөө хөгжлийн явцад аюулгүй байдлыг бэхжүүлэх мөнхийн эрх ашгийн өндөөс аюулгүй онцгой бүтэц, механизмыг байгуулан алдах, онох замаар туршлага хуримлуулан, төнийгээ сайжруулсаар иржээ. Аюулд өртөж болох салбар аюул учрах шалтаг, шалтгаан ч маш олон, заналхийллийн хэмжээ, шинж чанар янз бүр байх болохоор цэргийн албаны аюулгүй байдлыг хангах арга замыг боловсруулахад мөн л олон янзын агуулга зорилго бүхий өвөрмөц мэдлэг (шинжлэх ухаан) эзэмших, тусгай судалгаа явуулахыг шаардаж байна.

Аюулгүй байдлын тогтолцоо нь өөртөө тухайн аюулгүй байдлын зорилго, хич хэрэгслэл, хангах арга зам, байдлыг нэлэх хэмжээнийг агуулдаг.

Үндэсний аюулгүй байдлын онол арга зүйн үндэс нь: эрх аюул занал-хамгаалалт гэсэн 3 ойлголтыг багтаадаг билээ. Эндээс аюулгүй байдал гэж ямарваа нэгэн аюулаас хэн нэгний эрх ашиг хамгаалагдсан байдал гэж тодорхойлж болохоор байна. Тэгвэл цэргийн албан хаагчийн эрх ашгийг цэргийн албанд учирч буй аюул заналаас хамгаалсан, ард иргэд байгаль орчныг цэргийн үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалсан тийм аюулгүй байдлыг цэргийн албаны аюулгүй байдал гэж ойлгож болох юм.

Судлаач эрдэмтэд “цэргийн албаны аюулгүй байдал /ЦААБ/ гэх цэргийн /Зэвсэгт хүчин/ үйл ажиллагааны явцад өөсч болзошгүй аюул занал, сөрөг нөлөөллөөс ЦАХ, ард иргэд, байгаль хамгаалагдсан байдал” гэж тодорхойлсон.

ЦААБ-ын тогтолцоо нь цэргийн албаны аюулгүй байдлын объект, субъект тэдгээрийн хоорондын харилцааг зохицуулах эрх зүйн актуудаас бүрдэх ба тэр нь цэргийн албаны

аюулгүй байдлын аюул заналыг урьдчилан таамаглах, илрүүлэх, хязгаарлах, зайлуулах мөн объектуудын хамгаалалтыг хангахад субъектуудын үйл ажиллагааг тодорхойлох зорилготой гэж үзэж байна.

ҮНДСЭН ХЭСЭГ

Хил хамгаалах байгууллагын ЦААБ-ын нэр томъёоны шинжилгээг хийхийн тулд дараах хичин зүйлсийг харгалзан үзлээ. Үүнд:

Нэгдүгээрт: Хил судлалын шинжлэх ухааны онолтой холбож үзэх;

Хоёрдугаарт: ЦААБ-ын нэр томъёог шинжлэн тодорхойлсон эрдэмтдийн судалгаанд тулгуурлах;

Гуравдугаарт: Хил судлалын эрдэмтэн судлаачдын санал, зөвлөмж, ХХБ-ын удирдах ажилтнуудаас авсан санал асуулгад шинжилгээ хийх;

Дөрөвдүгээрт: Зэвсэгт хичин, Хил хамгаалах байгууллагын чиг үүрэг, тэдгээрийн ялгаатай байдал, хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааны онцлог зэрэгт тулгуурлан, үйл ажиллагааны чиглэлээр нь,

Тавдугаарт: Хил хамгаалах байгууллагын ЦААБ-тай холбоотой хэл зүйн болон цэргийн нэр томъёонуудын тодорхойлолтуудтай уялдуулан “Хил хамгаалах байгууллагын цэргийн албаны аюулгүй байдал” гэсэн онолын тодорхойлолтыг томъёолох.

Дээрх хичин зүйлсэд хийсэн судалгаа, түүнд тус ниймд үүнийг дүгнэлтийг дараах байдлаар нэгбүрчлэн авч үзье.

Нэгдүгээрт: ЦААБ-ын асуудал нь хил судлалын шинжлэх ухааны аль онол, чиглэлд хамаарч буйг судлахад: ХХБЦААБ-ын асуудал нь Хил судлалын шинжлэх ухааны хил хамгаалалтын тусгай онол, чиглэлийн хувьд цэрэг, аюулгүй байдлын ерөнхий онолд хамаарагдаж байна.

Хоёрдугаарт: ЦААБ-ын нэр томъёог шинжлэн тодорхойлсон эрдэмтдийн судалгаанд тулгуурлан судлахад: **Цэргийн албаны аюулгүй байдлын талаар гадаад дотоодын эрдэмтэд, эх сурвалжид дараах байдлаар тодорхойлжээ.**

ЗХ-нд цэргийн албаны аюулгүй байдлын хангах удирдлага нь цэргийн алба хаагчдын амьнас, эрүүл мэнд мөн орон нутгийн иргэд, түүнийг мч, хэрээлэн буй орчинд учирч болзошгүй хор хохиролоос урьдчилан сэргийлэх, цэргийн албанд хортой, аюултай хичин зүйлийг илрүүлэн оношлох, цэргийн алба хаах аюулгүй нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэсэн ОХУ-ын хууль тогтоомж, ЗХ-ний цэргийн дүрэм, БХЯ-ны эрх зүйн актуудад заасан шаардлагуудыг биелүүлэхэд чиглэсэн цэргийн анги байгууллагуудын удирдлага, албан тушаалтнуудын зорилго бүхий үйл ажиллагаагаар хэрэгждэг.¹

ЦААБ гэдэг нь цэргийн ангийн бие бүрэлдэхүүн, ЦХА нэг бүрийн алба хаах нөхцөлийг бүрдүүлэх, орон нутгийн ард иргэд, тэднийг мч, хэрээлэн буй орчныг дүр тутмын үйл ажиллагааны явцад бий болсон цэргийн албаны аюултай хичин зүйлийн нөлөөллөөс хамгаалахад оршино.²

“Цэргийн албаны аюулгүй байдал /ЦААБ/ гэж Зэвсэгт хичний үйл ажиллагааны явцад үүсч болзошгүй аюул, занал, сөрөг нөлөөллөөс ЦАХ, ард иргэд, байгаль орчны хамгаалагдсан байдал.”³ гэж;

1. ОХУ-ын ЗХ-ний цэргийн албаны аюулгүй байдлыг хангах удирдамж. Мос., 2015, 2,2 дугаар зүйл

2. Полковник А.Медведев. преподаватель ВНУЦ СВ “Общевойсковая академия ВС РФ”

3. Д.Эрдэнэцогт.“Цэргийн албаны аюулгүй байдлыг хангах үндэс”докторын зэрэг горилсон диссертаци. УБ., 2002. 140х, т65

Судалгаанаас үзэхэд цэргийн албаны аюулгүй байдал нь цэргийн алба хаагчдын гүйцэтгэж байгаа бөх үйл ажиллагаа (дүр тутмын цагийн хуваарьт ажиллагаа, байлдааны бэлтгэл, байлдааны жижүүлэлт, цэргийн зэвсэг, техникийн ашиглалт гэх мэт) болон цэргийн эд хогшил, байлдааны зэвсэг, техник, цэргийн ахуй амьдралын хэрэгцээт зүйлс, хүнс, ус, хэрээлэн буй орчин, авч хэрэгжүүлж буй арга хэмжээнээс шалтгаалж байдаг байна. Тайван цагийн цэргийн албаны аюулгүй байдлыг цэргийн алба хаагчдын эрүүл мэнд хохирох, техникийн осол гарах, гадны халдлага үйлдэгдэх болон хэрээлэн буй орчинд хортой нөхцөл үзүүлэх зэрэг болзошгүй эрсдлийг тодорхойлж, түүнээс сэргийлэх үйл ажиллагаа гэж ойлгож болно.

Цэргийн албаны аюулгүй байдал нь анги, салбарын байлдааны чадавхийг хангахад чухал нөлөөтэй байна. Үүнийг “...Зэвсэгт хүчний байлдааны чадавхи нь цэргийн сургалт, ур чадвар; техникийн хангамж, түүний тоо, чанар; бие бэрэлдэхүүний үзэл санааны хатуужил, ёс суртахуун, сахилга зохион байгуулалт; цэргийн онолын сэтгэлгээний хөгжлийн төвшин; удирдах бэрэлдэхүүний ур чадвар, бэлтгэлжилтийн зэргээр тодорхойлогдоно”⁴, “...Зэвсэгт хүчний үйл ажиллагааны явцад үүсч болзошгүй аюул занал, сөрөг нөхцөллөс ЦАХ, ард иргэд, байгаль орчны хамгаалдагдсан байдал гэж тодорхойлж байна”⁵ гэснээс харж болно. гэж;

Мөн доктор Б.Тэмэн: “Цэргийн албаны аюулгүй байдал нь: цэргийн алба хаагчдын гүйцэтгэж байгаа бөх үйл ажиллагаа (байлдааны бэлтгэл, байлдааны жижүүлэлт, байлдаан, цэргийн зэвсэг, техникийн ашиглалт гэх мэт)-ны аюулгүй байдал, түүнчлэн цэргийн эд хогшил, байлдааны зэвсэг, техник, цэргийн ахуй амьдралын хэрэгцээт зүйлс, хүнс, ус, хэрээлэн буй орчин, аюулгүй байдлаас шалтгаалж байдаг”⁶ хэмээн тус тус тодорхойлсон байна.

Дээрх тодорхойлолтуудаас ЦААБ нь “Тайван цагийн цэргийн албаны аюулгүй байдлыг цэргийн алба хаагчдын эрүүл мэнд хохирох, техникийн осол гарах, гадны халдлага үйлдэгдэх болон хэрээлэн буй орчинд хортой нөхцөл үзүүлэх зэрэг болзошгүй эрсдлийг тодорхойлж, түүнээс сэргийлэх үйл ажиллагаа гэж ойлгож болно” гэсэнтэй судлаачийн хувьд санал нийлж байна.

Харин хил хамгаалах байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаанаас шалтгаалан, энэхүү тодорхойлолтын байгаль орчинд хортой нөхцөл үзүүлэх гэдгийн оронд байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх гэсэн утгыг оруулж үргэх нь зүйтэй гэж үзлээ. Учир нь Хил хамгаалах байгууллага нь Зэвсэгт хүчний ангиудтай адил артиллерийн зэвсэглэл хэрэглэдэггүй, зөвхөн хүн нэг бөрийн болон тасаг, салааны зэвсэглэл хэрэглэдэг билээ.

Гуравдугаарт: Хил судлалын эрдэмтэн судлаачдын санал, зөвлөмж, ХХБ-ын удирдах ажилтнуудаас авсан санал асуулгад шинжилгээ хийхлээ. Үүнд:

Эдгээр эрдэмтдийн санал, зөвлөмжийг нэгтгэн дүгнэхэд: ХХБ-ын ЦААБ-ын асуудал нь хилчид УХХ-х үндсэн үүргээ хэрэгжүүлэх дүр тутмын үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах асуудал гэж ойлгогдож, цэргийн болон ОХУ-ын эрдэмтдийн дэвшүүлсэн онолын ойлголтуудтай ижил агуулгатай болох нь харагдаж байна.

Дүрмд үзвэл: Зэвсэгт хүчний тайван цагийн гол үүрэг нь байлдааны болон дайчилгааны бэлэн байдлыг хангах, түүнд бие бэрэлдэхүүнийг бэлтгэхэд чиглэж байдаг

4. Цэргийн нэр томъёоны тайлбар толь. УБ., 2014. 702х., т77;

5. Эрдэнэцогт. Д., “Цэргийн албаны аюулгүй байдлыг хангах үндэслэл” сэдэвт докторын зэрэг горилсон диссертаци. УБ., 2002. 140х., т65;

6. Тэмэн. Б., Байлдаанд цэргийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо. Гарын авлага, УБ., 2005. 30х.,

бол Хил Хамгаалах Байгууллагын Үндсэн Үүрэг нь хилийн асуудлаар байгуулсан Монгол улсын олон улсын гэрээ хэлэлцээр, Монгол Улсын Хилийн тухай хууль, тогтоомжийг сахиулахад чиглэсэн байдаг. Үүгээрээ Зэвсэгт хүчний бие бэрэлдэхүүн сургалт, бэлэн байдлын объект болж байхад Хил хамгаалах байгууллагын бие бэрэлдэхүүн хил хамгаалах Үйл ажиллагааны субъект болж байдгаараа эрс ялгаатай юм.

Энэ бөгөөд үзэхэд тэмцэл явуулах объектоос шалтгаалаад тухайн субъектийн Үйл ажиллагааны зорилго, зорилт, арга, хэлбэр, хүч хэрэгсэл, бүтэц зохион байгуулалт харилцан адилгүй байх бодит зүй тогтол байгаа нь харагдаж байна.

Үүнээс үүдээд улсын хил хамгаалах байгууллага нь Үндэсний аюулгүй байдлыг хангах Үйл ажиллагаанд Үүрийн гэсэн байртай, Үүрэг рольтой Өвөрмөц субъект болох нь харагдаж байна. Үндэсний аюулгүй байдлыг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Үзэл баримтлалд тодорхойлохдоо: “Монгол улсын Үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ” гэсэн байдаг.

Улсын хил хамгаалалтын мөн чанар нь хязгаар нутагт дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлдэгт оршино. Үүрэг хэлбэл: Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хилийн боомт, хязгаар нутагт аюулгүй байдлыг сахиулах тэр, нийгэм, иргэдийн ашиг сонирхлыг хамгаалах ажиллагааг улсын хил хамгаалалт гэж ойлгодог. Ийнхүү Үндэсний аюулгүй байдлыг хангахад хил хамгаалах Үйл ажиллагаа нь хязгаар нутагт голлох үүрэгтэй байдаг. Энэ нь хил судлалын шинжлэх ухааны зорилго, объект, судлах зүйл зэргээс тодорхой харагдаж байна.

Дээрхээс улсын хил хамгаалах байгууллагын Үндсэн чиг үүрэгтэй нь уялдуулж, ЦААБ-ыг хангах чиглэлийг гаргаж болох юм. ХХБ-ын Үндсэн чиг үүрэг нь “Улсын хил хамгаалалт бүрд” хилийн тухай хуулийн 35 дугаар зүйлд нарийвчлан тодорхойлон тусгажээ.

Мөн МУ-ын хилийн тухай хуульд: “Улсын хил хамгаалалт нь Үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний салшгүй хэсэг мөн. Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, Монгол Улсын хилийн хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн зөрчлөхс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн зурвас, боомт, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, цэргийн, инженер-техникийн, мэдээлэл технологийн, тагнуулын, хилийн төлөөлөгчийн арга хэмжээг хослуулан явуулж байгаа Үйл ажиллагааг улсын хил хамгаалалт гэнэ.

Газар, усан дээрх улсын хилийг улсын хил хамгаалах байгууллага, агаарын хилийг зэвсэгт хүчний агаарын цэрэг хамгаална.”⁷ Эндээс:

- улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах,
- зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх,
- цэргийн,
- инженер-техникийн,
- мэдээлэл технологийн,
- тагнуулын,
- хилийн төлөөлөгчийн арга хэмжээнүүдийг явуулах Өөрийн аюулгүй байдлыг хангах асуудал нь Үүрэг ХХБ-ын ЦААБ-ыг хангах Үйл ажиллагааны чиглэлүүд болж болох юм гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Мөн дээрх арга хэмжээнүүдийг хослуулан явуулах үеийн аюулгүй байдлыг хангах нь ХХБЦААБ гэж ойлгогдож байна.

Тавдугаарт: Хил хамгаалах байгууллагын ЦААБ-тай холбоотой хэл зүйн болон цэргийн нэр томъёонуудын тодорхойлолтуудтай уялдуулан “Хил хамгаалах байгууллагын цэргийн албаны аюулгүй байдал” гэсэн онолын тодорхойлолтыг томъёолохыг зорьё. Үүнд:

Цэргийн алба хаагч: Хууль тогтоомжийн дагуу цэргийн жинхэнэ алба хааж байгаа иргэн. ЦАХ бүр хашиж буй албан тушаалдаа тохирох цэргийн цолтой байна. Зэвсэгт хичний Ц.а.х-ыг офицерийн бүрэлдэхүүн(дунд, ахлах, дээд), ахлагчийн бүрэлдэхүүн, гэрээт цэргийн ба хугацаат цэргийн алба хаагч (цэрэг, тэрүүч) гэж ангилдаг. Ц.а.х. нь цэргийн тангараг бүрх журамтай.⁸

Цэргийн албан: Цэргийн хүрээ, нэгтгэл, ангид цэргийн амьдрал, ахуй, сургалтыг хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэх, дүрмээр тогтоосон журам, цэргийн сахилгыг сахиулах талаар хэрэгжүүлэх үүрэг тутмын үйл ажиллагаа. Ц.а-ыг цэргийн тэрүүл бүрийн дүрэм, заавар, зааварчилгаа, дээд шатны командлалын тушаал, захирамжийн үндсэн дээр захирагч, штабаас зохион байгуулж хэрэгжүүлнэ. Цэргийн албан нь дотоодын алба харуулын алба, цэргийн албаны аюулгүй байдлыг хангах болон бусад асуудлыг үүрэгт багтаана.⁹

Цэргийн албаны аюулгүй байдал: Цэргийн албаны аюулгүй байдал /ЦААБ/ гэж Зэвсэгт хичний үйл ажиллагааны явцад үүсч болзошгүй аюул, занал, сүрэг нөлөөллөөс ЦАХ, ард иргэд, байгаль орчны хамгаалагдсан байдал.

Цэргийн анги, салбарын аюулгүй байдал: Тайван цагт байлдааны байнгын бэлэн байдлыг хангах, дайны байдлын үед байлдааны бэлэн байдлыг дээд зэрэгт шилжих үеийн цэргийн албаны аюулгүй байдал хангагдсан байх түүх¹⁰

Хилийн аюулгүй байдал: Хилийн аюулгүй байдал гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсаныг хэлнэ.¹¹

Хил хамгаалах байгууллага/ХХБ/: “Улсын хил хамгаалах байгууллага” гэж Монгол улсын хэмжээнд улсын хил хамгаалалтыг зохион байгуулах, удирдах үүрэг бүхий тэрийн захиргааны байгууллага, түүний харьяа хилийн цэргийн анги, салбарыг хэлнэ¹²

ХХБ-ын цэргийн алба:

1. Цэргийн алба нь Хил хамгаалах байгууллагын хэмжээнд Монгол Улсын үндсэн хууль болон бусад хууль, тогтоомжид заасан үүргийг биелүүлэх, Цэргийн болон Хил хамгаалалтын дүрмээр тогтоосон хэм хэмжээг мөрдөх, үүрэг тутмын үйл ажиллагааны хэвийн нөхцлийг бүрдүүлэх, цэргийн чанд сахилга, хил хамгаалалт, албаны үйл ажиллагааны бэлэн байдал, жижүүрлэлтийн алба, харуул, хоногийн манааг зохион байгуулж удирдах арга хэмжээ юм.

2. Цэргийн болон хил хамгаалалтын дүрмүүд, дээд шатны дарга \захирагч\ нарын тушаал, захирамжуудыг үндсэн удирдлага болгон бүх шатны дарга нар цэргийн албыг зохион байгуулж хэрэгжүүлнэ.

8. Цэргийн нэр томъёоны тайлбар толь. УБ., 2014. 702х, т344

9. Мөн тэнд УБ., 2014. 702х, т346

10. Д.Мандахбаяр “Артиллерийн анги салбарын аюулгүй байдлыг хангах зарим арга зам” докторын зэрэг горилсон диссертаци. УБ., 2018. 167х, т4

11. “Хилийн тухай хууль”. УБ.,2016. 5.2 дугаар зүйл.

12. “Хилийн тухай хууль”. УБ.,2016. 3.1.11 дүгээр зүйл.

3. Цэргийн албаны зохион байгуулалтад: - Дотоод алба; - Хэрээний ба харуулын алба; - Зохицуулагчийн ба автотехникийн шалгах алба; - Галын аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ - Албан хэрэг хяналт орно.¹³

Судлаачын хувьд дээрх тодорхойлолтууд, аюулгүй байдлын онол, тогтолцоо, ЦААБ-ын онол арга зүйг судлах явцад ЦААБ-ыг хангах нэг чиглэл нь нь албаны хяналт, шалгалт гэж ойлгогдсон тул ХХБЦААБ-ыг дараах байдлаар тодорхойлж байна. **Нд:**

Нийтлэг утгаараа: “Улсын хил хамгаалалт, хилийн ангийн цэргийн алба, хяналтын албаны явцад эрх аливаа эрсдэл, байгалийн гамшиг, аюул, занал, сөрөг нөхцөл бие бүрэлдэхүүн, ХХТХГ-дийн хамгаалагдсан байдал, тэдний ажиллаж, амьдрах аюулгүй нөхцөлийг бүрдүүлэх, байгаль, орчныг хамгаалах, ХХБЦААБ-ыг хангах албаны бэлтгэлжилт, хяналт шалгалтын цогц арга хэмжээ, тогтолцоог ХХБ-ын цэргийн албаны аюулгүй байдал./цаашид ХХБЦААБ гэнэ/ хэлнэ.”

Товчхоноор илэрхийлбэл: “Улсын хил хамгаалалт, хилийн ангийн цэргийн албаны үйл ажиллагааны явцад эрх аливаа эрсдэл, байгалийн гамшигт зэгдлээс бие бүрэлдэхүүний хамгаалагдсан байдал, тэдгээрийг хангах цогц арга хэмжээг ХХБ-ын цэргийн албаны аюулгүй байдал./цаашид ХХБЦААБ гэнэ/ гэнэ.”¹⁴

Дүгнэлт

Судалгаанаас нэгтгэн дүгнэхэд: ХХБЦААБ-ын асуудал нь хилчид УХХ-х үндсэн үүргээ хэрэгжүүлэх үүднээс тутмын үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах асуудал гэж ойлгогдож, цэргийн болон ОХУ-ын эрдэмтдийн дэвшүүлсэн онолын ойлголтуудтай ижил агуулгатай болох нь харагдаж байна.

Мөн “Улсын хил хамгаалах байгууллага” /ХХБ/ гэж Монгол Улсын хэмжээнд улсын хил хамгаалалтыг зохион байгуулах, удирдах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, төрийн харьяа хилийн цэргийн анги, салбарыг хэлнэ¹⁵ гэснээс дүгнэхэд Хил хамгаалах байгууллага-Хилийн цэрэг нэг байгууллагыг илэрхийлж байна.

Арга зүйн зөвлөмж болгоход:

Зэвсэгт хүчний орчин үеийн хөгжлийн үе шатанд цэргийн албаны аюулгүй байдлын асуудлыг авч үзэхийн чухал болохыг ОХУ-ын туршлага харуулж байна. Юуны үүднээс цэргийн албаны аюулгүй байдал бол янз бүрийн тодорхойлолт ба хэлбэрээр илрэх ерөнхийлөн дүгнэсэн ойлголт гэдэгт анхаарал хандуулах хэрэгтэй.

Судлаачийн хувьд: Хил хамгаалах байгууллагын цэргийн албаны аюулгүй байдал /ХХБЦААБ/ нь бүх төрлийн ААХЗ, дотоод албаны болон цэргийн дүрмийг хэрэгжүүлэх ЦАЗБ, цэргийн аж ахуйн болон улсын хил хамгаалалт, төнд шаардлагатай үйл ажиллагаануудын стандартуудаас бүрдэх ба ЦАХ-дын албан үүргээ гүйцэтгэх үед учирч болох аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх цогц үйл ажиллагаа, эрүүл аюулгүй орчин, ЦААБ-ыг хангахад тавих хяналт шалгалтын цогц юм.

САНАЛ

Дээрх судалгаанаас үндэслэн Хил хамгаалах байгууллагын Цэргийн албаны аюулгүй байдлын онол, арга зүй, нэр томъёоны дээрх асуудлуудыг Хил хамгаалах байгууллагын хэмжээнд нэг ойлголтыг бий болгон, эрх зүйн зохицуулалтын хувьд холбогдох зааварт тусган

13. Хил хамгаалах байгууллагын цэргийн албаны зохион байгуулалтын заавар. УБ.,2019. 1.1 дэх заалт

14. Судлаачын тодорхойлолт

15. “Хилийн тухай хууль”. УБ.,2016.3.1.11 дүгээр зүйл.

баталгаажуулан, практикт нэвтрүүлэх нь ХХБЦААБ-ын нөөгийн байдалд шинжилгээ хийн, нийгэм, эдийн засаг, техник, технологийн өөрчлөлтийн нөхцөл байдалтай уялдуулан цаашид хэрхэн сайжруулах арга замыг тодорхойлох өндэс болох юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. МУ-ын Хилийн тухай хууль. УБ., 2016. 31 дүгээр зүйл
2. ОХУ-ын ЗХ-ний цэргийн албаны аюулгүй байдлыг хангах удирдамж. Мос.,2015. 2,2 дугаар зүйл
3. Полковник А.Медведев. преподаватель ВНУЦ СВ “Общевойсковая академия ВС РФ” Цэргийн нэр томъёоны тайлбар толь. УБ.,2014. 702х,, т77;
4. Эрдэнэцогт.Д., “Цэргийн албаны аюулгүй байдлыг хангах өндэслэл” сэдэвт докторын зэрэг горилсон диссертаци. УБ.,2002.140х,т65;
5. Тэмэн.Б., “Байлдаанд цэргийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо”. Гарын авлага, УБ.,2005.30х,т3.
6. Хил хамгаалах байгууллагын цэргийн албаны зохион байгуулалтын заавар. УБ.,2019.1.1 дэх заалт
7. Д.Мандахбаяр “Артиллерийн анги салбарын аюулгүй байдлыг хангах зарим арга зам” докторын зэрэг горилсон диссертаци. УБ.,2018.167х,т4
8. “Хил хамгаалах байгууллагын цэргийн албаны аюулгүй байдлыг хангах арга зам” судалгааны ажлын 1 дүгээр бүлгээс.